

**2013 оны Эрдэнийн Говь арга хэмжээн дээр хэлсэн үг**  
**2014 оны 4 дүгээр сарын 29**  
**Галсангийн Батсүх, Оюу Толгой ХХК-ийн ТУЗ-ийн дарга**

УИХ-ын эрхэм гишүүд, сайд нар, Өмнөговь аймгийн удирдлага, Оюу Толгой компанийн ТУЗ-ийн гишүүд, компанийн хувь нийлүүлэгчид, бэлтгэн нийлүүлэгч компаниуд, Оюу Толгой компанийн хамт олон, эрхэмсэг хатагтай, ноёд, зочид, төлөөлөгчид та бүхний энэ өдрийн түмэн амгалан эрэн мэндчилье.

Энэ танхимд хуран цугласан зочдын олонхи нь манай Оюу Толгойн ханган нийлүүлэгч, хамтран ажиллагч компаниудын төлөөлөл юм. Өнөөдөр бид хамтын ололт, амжилтаа ёслол төгөлдөр тэмдэглэхээр 5 дахь жилдээ энд цуглараад байна.

Дэд бүтэц төдийлэн сайн хөгжөөгүй Өмнийн говьд Оюу Толгой хэмээх уул уурхайн иж бүрэн цогцолборыг та, бид хамтын хүчин чармайлтаар гуравхан жилийн дотор цогцлуулан бүтээж чадсан билээ. 2013 оны зун Оюу Толгойн анхны баяжмал экспортод гарсан нь Монголын уул уурхайн боловсруулсан бүтээгдэхүүний шинэ брэндийг олон улсын зах зээлд төрүүлсэн юм. Та, бид Оюу Толгойнхоо түүхийн энэхүү бахархуштай шинэ хуудсыг хамтдаа бичилцсэн. Энэхүү амжилт нь ханган нийлүүлэгч компаниуд, тэдний ажиллагсдын мэдлэг, чадвар, хичээл зүтгэл, нөр их хөдөлмөртэй салшгүй холбоотойг зориуд цохон тэмдэглэж байна.

Оюу Толгой ХХК өнгөрсөн онд 950 үндэсний ханган нийлүүлэгчээс бараа, үйлчилгээ худалдан авчээ. Эдгээр компани, үйлдвэрүүдэд 35 мянган гаруй ажилчин, инженер, техникийн мэргэжилтэн нар хөдөлмөрлөдөг.

Бид сүүлийн 3-хан жилийн дотор мянга гаруй компаниудыг нэгтгэсэн үндэсний хамгийн том хангамжийн сүлжээг бий болгож чадлаа. Гурван жилийн өмнө дээрх тоо гарын 10 хуруунд л багтаж байсныг дашрамд тэмдэглэе.

Оюу Толгойтой хамтран ажилладаг компани бүрт шинэ ажлын байр бий болж, тэнд ажиллаж буй иргэдийн аж амьдрал дээшилж буй тухай сонсох бүртээ миний бие үндэснийхээ компани, үйлдвэрүүдээр бахархаж явдаг юм.

Та бүхэн бараа, бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ олон улсын чанар, стандарт, дээд зэргийн аюулгүй ажиллагааны болон хөдөлмөрийн сахилга батыг чанд мөрдөхөд давхар суралцаж, түүнийгээ Монголынхоо хөрсөнд нутагшуулж буйгаараа бахархах эрхтэй хүмүүс. Энэ бол “Оюу Толгой”-той хамтран ажиллаж байгаа үйл явцаас хүртэж буй нэн чухал үр ашгийн нэгэн жишээ. Монголдоо амьдарч, Монголдоо суралцаж, Монголдоо бүтээхийн амьд жишээ, ач холбогдол энэ буюу.

Өнөөдөр “Оюу Толгой уурхайн цогцолбор”-ын олборлолт, үйлдвэрлэлт, экспорт хэвийн явагдаж байна.

Ирж буй он жилүүдэд бид бага зардлаар ихийг хийж бүтээх, үр ашгаа дээшлүүлэхэд онцгой анхаарах болно. Мөн нэгэнт бүрдүүлсэн үндэсний хангамжийн сүлжээгээ цаашид улам өргөжүүлэх, энэ хүрээнд импортын түүхий эд, материалыг орлуулах үйлдвэрлэлийг боломжийн хэрээр дэмжин хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх амаргүй зорилт тавьж байна. Иймд дээрх чиглэлд бүтээлч, үр дүнтэй бөгөөд харилцан ашигтай хамтран ажиллахыг уриалж байна. "Дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг" гэдэг билээ. Хамтран зүтгэж, хамтран бүтээцгээе.

"Эрдэнийн говь" ёслолын арга хэмжээ ийнхүү албан ёсоор нээгдсэнийг мэдэгдье. Та бүхэнд Оюу Толгой компанийн ТУЗ-ийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, улам их амжилт хүсэн ерөөе.